

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨМЖ (2012 он)

Зөвлөмж 201203/01. Боинг 767 агаарын хөлөг, Rolls Royce RB211-524C2 хөдөлгүүрт нислэгт тэнцэх чадварыг хадгалах талаар эрх бүхий байгууллагаас гаргасан нислэгт тэнцэх чадварын удирдамж /AD/, сервис бюллетень /SB/-ийн хэрэгжилтийг Боинг 767-3W0 ER, JU1011, JU1012 агаарын хөлгүүд, түүний хөдөлгүүрт хийгдсэн байдлыг шалгаж дүгнэлт гаргах.

Зөвлөмж 201203/02. Техник үйлчилгээний загвар /BOENG767 MAINTENANCE MANUAL 72-03-00/-ын RB.211-524 серийн хөдөлгүүрийн В. Combustion Case Fairings хэсэгт RB211-72-D674 бюллетенийн аргачлал ороогүй байгааг судалж холбогдох арга хэмжээг авах.

Зөвлөмж 201203/03. Боинг 767-3W0 ER, JU1011 агаарын хөлгийн хөдөлгүүрүүдэд Combustion Fairing-ийн суурь өөр байгаатай холбогдуулан техник үйлчилгээний ажилтнуудад өөрчлөлтийн талаар танилцуулах сургалт зохион байгуулах.

Зөвлөмж 201203/04. Боинг 767-3W0 ER, JU1011 агаарын хөлгийн зүүн хөдөлгүүрийн 6 ширхэг тулгуур /fairing support block FW25830/-ын 12 ширхэг зөөлөвчийг шинээр тавих.

Зөвлөмж 201203/05

Боинг 767-3W0 ER, JU1011, JU1012 агаарын хөлгүүдийн Combustion Fairing-ийн үндсэн түгжээний тохируулгыг шалгаж холбогдох арга хэмжээг авах.

Зөвлөмж 201203/06. Техник үйлчилгээний болон дотоод хяналт, чанар, баталгаажуулалтын удирдлага, зохион байгуулалтыг оновчтой хэлбэрт оруулах.

Зөвлөмж 201203/07. Чингис хаан нисэх буудлын 142 градусын буултын оролтын төгсгөлийн үед аэродромын хязгаарлалтаас газардах цэг хүртэлх орчинд үүсэх “ Wind shear”-ийг тодорхойлж , нислэг үйлдэж байгаа нисэх багт мэдээлэх систем бий болгож мөрдөх

Зөвлөмж 201203/08. Салхины огцом өөрчлөлт “ Wind shear”-ийн үүсэх цаг уурын синоптик нөхцөл, нислэгт үзүүлэх нөлөөлөл, мэдээлэл дамжуулах, анхааруулга өгөх сэдвээр НХҮА,НЦУТ-д сургалт зохион байгуулах

Зөвлөмж 201203/09. Агаарын хөлгийн битүүмжлэл алдагдах болон нислэгийн аливаа хэвийн бус нөхцөл үүссэн тохиолдолд нисэх баг нислэгийн ашиглалтын заавар журам, “CHECK LIST”-ийг мөрдөх ажиллагааг хэвшүүлэх

Зөвлөмж 201203/10. Агаарын хөлөгт байрлуулсан нислэгийн өгөгдөл бичигч /FDR/, бүхээгийн ярианы бичлэг /CVR/-ийн төхөөрөмжүүдийн ажиллагааг тогтмол хянаж, байнгын бүрэн ажиллагаатай байлгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Зөвлөмж 201203/11. Нислэгийн өгөгдөл бичигч /FDR/-ийн төхөөрөмжийн бичлэгийг тайлах арга хэмжээг өөрийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхдээ нислэг, техникийн зөрчил, дутагдлын шалтгааныг тогтоож, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, нисэх бүрэлдхүүний ур чадварыг дээшлүүлэх зорилгоор ашиглах

Зөвлөмж 201205/14. Агаарын хөлгийн мөстөлтөөс хамгаалах, арилгах тусгай шингэний төрөл, найрлагыг баталгаажуулах

Зөвлөмж 201205/15. Мөстөлтөөс хамгаалах, арилгах тусгай шингэнтэй хольж хэрэглэх усны найрлага, стандартыг баталгаажуулах

Зөвлөмж 201205/16. Агаарын тээврийн компаниудаас гаргасан, “Агаарын хөлгийн мөстөлтөөс хамгаалах, арилгах заавар”-ын дагуу газрын үйлчилгээ үзүүлэгч байгууллага авч хэрэгжүүлж ажиллах

Зөвлөмж 201205/17. Агаарын хөлгийн мөстөлт арилгах, хамгаалах үйл ажиллагаанд оролцогч байгууллагууд энэ ажиллагаанд хамаарах боловсон хүчнийг мөстөлт арилгах, хамгаалах ажиллагааны заавар, технологи ажиллагаанд сургах,бэлтгэх давтан сургах сургалтын хөтөлбөртэй болох, хэрэгжүүлэх.

Зөвлөмж 201210/18. SAAB340, JU-9903 Агаарын хөлөгт одоо ашиглагдаж байгаа СТ-7-9В GE-E 785328 дугаартай хөдөлгүүрт дахин үзлэг хийж болсон байдлыг үйлдвэрлэгчид мэдэгдэж хариу шийдвэр иртэл ашиглахгүй байх.

Зөвлөмж 201210/19. Нислэгт ашиглах нөхцөл бүрдсэн үед нислэгийн үед дахин хөдөлгүүрийн турбины оролтын ИТТ температур өссөн тохиолдолд хөдөлгүүрийг ашиглахгүй их засварт явуулах

Зөвлөмж 201210/20. Компанийн нислэг, техникийн ажлын уялдаа холбоог сайжруулах, гарсан дутагдал зөрчилд нэгдсэн шийдвэр гаргаж ажиллах

Зөвлөмж 201210/21. Нислэгийн ашиглалтын зааврыг мөрдөж ажиллаагүй нисгэх бүрэлдхүүнийг сургалтанд хамруулж холбогдох арга хэмжээг авах

Зөвлөмж 201211/22. Үйлдвэрлэгчээс гаргасан зааврын дагуу В737-800 агаарын хөлгийн дутагдлын мэдээлэл хадгалах PSEU BITE тестийг зөв хийх, түүний аргачлалд мэргэжилтнүүдийг сургаж дадлагажуулах

Зөвлөмж 201211/23. В737-800, EI-CSG агаарын хөлгийн хөөрөлтийн үед Take off Configuration Warning системийн дуут дохио, гэрэл ассан дутагдлыг дохиолол өгч болох бүх нөхцлийг шалгах, тухайн эд ангиудын тохиргоог шалгаж дахин гарахаас сэргийлэх

Зөвлөмж 201211/24. Улаанбаатар хотын Чингис хаан нисэх буудлын үндсэн зурвас RWY 14,32-т хийгдсэн нэмэлт хучилтын залгаасуудад үзлэг шалгалт хийж үүссэн байж болох эвдрэл, гэмтэл, түвшингийн өөрчлөлтүүдийг засварлах.

Зөвлөмж 201212/27. Хөдөлгүүрийн нөхцөл байдал /Engine On-Condition Maintenance Program/-аар техник үйлчилгээг хийхдээ хөдөлгүүрийн ажиллагаанд хяналт тавих /Engine condition trend monitoring/-нд нислэгийн өгөгдлийн бичлэг /FDR/ ба QAR-ийг ашиглан хийж хэрэгжүүлэх.

Зөвлөмж 201212/28. Агаарын хөлөгт гарсан дутагдлуудыг агаарын хөлгийн дэвтэр /aircraft log book/-т тэмдэглэх түүний дагуу авсан арга хэмжээг тодорхой бичиж байх

Зөвлөмж 201212/29. Хөдөлгүүр, сэнсний цагийн тооцоог зөв хийх, түүнд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх, шилжилт хөдөлгөөнийг холбогдох баримт бичиг (Engine log book /-т тодорхой тусгадаг болох.

Зөвлөмж 201212/30. Нислэгийн үйл ажиллагааны заавар /Flight operations manual Part A/-г компанийхаа одоогийн бодит үйл ажиллагаатайгаа нийцүүлэн боловсруулж хэрэгжүүлэх

Зөвлөмж 201212/31. Нислэгийн үйл ажиллагааны заавар /Flight operations manual Part B/-г тус компанид ашиглагдаж байгаа агаарын хөлгийн төрөл бүрт нийцүүлэн боловсруулж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх.

Зөвлөмж 201212/32. Нислэгийн үйл ажиллагааны заавар /Flight operations manual Part C/-г тус компанийн нислэг үйлдэж байгаа нислэгийн чиглэлүүдийг тусгаж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх.

Зөвлөмж 201212/33. Тус компанид ашиглагдаж байгаа агаарын хөлгүүдийн навигацын тоног төхөөрөмжүүдийг аль болох ижил төрлийн болгох, өөр байгаа тохиолдолд тухайн тоноглолд нисгэх бүрэлдэхүүнийг сургаж дадлагажуулах, ашиглалтын заавруудыг бэлтгэж хэрэгжүүлэх.

Зөвлөмж 201212/34. Төвлөрөлт тооцооны хуудас / Weight and Balance Sheet/-г агаарны хөлөг тус бүрд нийцүүлэн боловсруулж эрх бүхий байгууллагаар баталгаажуулж хэрэгжүүлэх.

Зөвлөмж 201212/35. Агаарын хөлгийн үйл ажиллагааны заавар /AOM/, агаарын хөлгийн нислэгийн заавар /AFM/, онцгой тохиолдлын үеийн заавар /ABNORMAL PROCEDURES/-г нисгэх бүрэлдхүүнд давтан сургалтыг зохион байгуулж үйл ажиллагаандаа хэвшүүлэх.

Зөвлөмж 201212/36. Туршлага багатай нисгэх багийн гишүүдийг томилох ажиллагааны шаардлага /Flight Operations manual Part A 4.1.4/-ийн цагийг нэмэгдүүлж үйл ажиллагаандаа нийцүүлэн хэрэгжүүлэх.

Зөвлөмж 201212/37. Аэродром дээрх цаг агаарын мэдээний таарц салхины чиглэл болон хурдыг нарийвчлан тогтоож өгөх.

Зөвлөмж 201212/38. Аэродромын цаг агаарын аюултай мэдээ /SPECI/-г боловсруулах, мэдээллийн санд байгаа METAR мэдээний цаг агаарын үзэгдлийн өгөгдхүүний тоон утгыг зөрүүгүй байлгах.

Зөвлөмж 201212/39. Цаг агаарын мэдээний хангалтанд ашиглагдаж байгаа тоног төхөөрмжийн цагийг тухайн орон нутгийн эсвэл олон улсын цагийн аль нэгэнд тохируулан ашиглах.

Зөвлөмж 201212/40. Цаг агаарын үйлчилгээний үйл ажиллагааны зарчмыг тодорхойлсон заавар, зөвлөмжинд гарсан өөрчлөлтийг тогтсон хаягийн дагуу тухай бүр тогтмол хийж хэрэгжүүлэх.

Зөвлөмж 201212/41. Нислэгийн удирдагчийн ажлын цагийн үргэлжлэх хугацааг тогтоосон норм журамд нийцүүлэн ажиллуулах.

Зөвлөмж 201212/42. Гэрэл дохиоллын AV425-RF системийг аэродромын хөөрч, буух зурвасанд ашиглахыг хориглох.

НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБА

ААТБ